

ЗАСГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН 428 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН “ТӨРӨӨС ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ 2020 ОН ХҮРТЭЛ БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

/2016 оны 9 дүгээр сарын 01-ний байдлаар/

№	Хяналтад авсан заалт, биелүүлэх хугацаа, хариуцах байгууллага	Хэрэгжилтийн явц		Удаашралтай хэрэгжиж буй шалтгаан	Цаашид авах арга хэмжээ
		Бодлогын баримт бичиг хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын явц /хувь/	2016 онд жилд хийсэн ажлын явц /хувь/		
1.	2.	3.	4.	5.	6.
1.	<p>Иргэний нисэхийн холбогдолтой Олон улсын дараах конвенцуудад нэгдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Агаарын хөлгөөр гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх тухай конвенци (Монреал, 2009 он); Агаарын хөлөгт гарсан хууль бус үйлдлийн улсаас гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх тухай конвенци (Монреал, 2009 он); Иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенци (Бээжин, 2010 он); Агаарын хөлгийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцийн нэмэлт протокол (Бээжин, 2010 он). <p>Хүрэх үр дүн: Олон улсын конвенци, протоколд нэгдэн орсон байна. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт сайжирна. Хугацаа: 2014-2016 он АТЭЗЗГХАГ</p>	<p>3 конвенц, 1 протоколд нэгдвэл манай улсын хүлээх үүргийг дахин нягтлан, эдийн засгийн үр өгөөжийн шинжилгээ, судалгаа хийж, танилцуулгыг 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 01/574 албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас ирүүлсэн. Дээрх конвенцид хийсэн эдийн засгийн үр ашгийн шинжилгээгээр тухайн нөхцөл үүссэн эсэхээс үл хамааран олон улсын арилжааны нислэгээр тээвэрлэсэн зорчигч, болон илгээсэн тонн ачаа тутмаас Олон Улсын Сангийн гишүүнчлэлийн татварыг албан ёсоор суутгахаар тусгасан тул зорчигч урсгал багатай манай орны хувьд агаарын тээвэрлэгчдийн санхүүгийн үр ашгийг бууруулахаар байгаа тул конвенцэд нэгдэх асуудлыг хойшлуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн хариуг 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 01/3380 тоот албан бичгээр Зам, тээврийн яамнаас ирүүлсэн.</p> <p align="right">/Хэрэгжилт 50%/</p>		<p>Бодлого өөрчлөгдсөн, хөрөнгө оруулалт их шаардагдах ажил тул эдийн засгийн нөхцлөөс шалтгаалж хэрэгжих хугацааг хойшлуулах чиглэл Зам, тээврийн сайд өгсөн.</p>	<p>Конвенцид нэгдэн орох асуудлыг 2016 он хүртэл хойшлуулах нь зүйтэй гэж ЗТЯ-аас шийдвэрлэсэн.</p>
2.	<p>Иргэний нисэхийн тухай хуулийн төсөл/шинэчилсэн найруулга/-ийг батлуулна. Хүрэх үр дүн: <i>Хуулийг батлуулж, хэрэгжүүлсэн байна. Иргэний нисэхийн хууль эрх зүйн орчин сайжирна.</i> Хугацаа: 2014 он НААХЗГ АТЭЗЗГХАГ</p>	<p>Иргэний нисэхийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын 2015.10.05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хуулийн төслийн үзэл баримтлалыг хамтран батлуулахаар Хууль зүйн сайдад хүргүүлсэн. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, ИНЕГ-ын даргын</p>	<p>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хууль зүйн яам болон бусад яамдаас ирүүлсэн саналуудыг судлан үзэж, хуулийн төсөлд тусган, эцсийн байдлаар холбогдох тайлбарын хамт Зам,</p>		<p>Хуулийн төслийг “Тээврийн ерөнхий хууль”-ийн үзэл баримтлал, төсөлтэй уялдуулан боловсруулж, батлуулахаар холбогдох дээд байгууллагад хүргүүлэх</p>

	<p>НБУГ НХУГ ХЭЗГ</p>	<p>зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 2015.11.13-ны өдрийн 01/2766 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хууль зүйн яам болон бусад яамдаас ирүүлсэн саналуудыг судлан үзэж, хуулийн төсөлд тусган, эцсийн байдлаар холбогдох тайлбарын хамт Зам, тээврийн яаманд 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/662 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Иргэний нисэхийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Хууль, зүйн сайд, Зам, тээврийн сайд хамтран баталсан.</p> <p style="text-align: center;">/Хэрэгжилт 70%/</p>	<p>тээврийн яаманд 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/662 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Иргэний нисэхийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Хууль, зүйн сайд, Зам, тээврийн сайд хамтран баталсан. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч “Тээврийн ерөнхий хууль”-ийн үзэл баримтлал, төсөлтэй уг хуулийн төслийг уялдуулан боловсруулах чиглэлийг ЗГХЭГ-аас өгөөд байна.</p> <p style="text-align: center;">/Хэрэгжилт 70%/</p>		
3.	<p>Агаарын хөлгийн шатахууныг үйлдвэрлэгчээс худалдан авах журмыг Засгийн газраар батлуулна. Хүрэх үр дүн: <i>Журам батлагдсан байна.</i> <i>Агаарын хөлгийн түлш, шатахууны үнэ буурна.</i> Хугацаа: 2014-2015 он АТЭЗЗГХАГ</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуультай зөрчилдөх тул агаарын хөлгийн шатахууныг үйлдвэрлэгчээс худалдан авах зохицуулалтыг бүрдүүлэх боломжгүй байгаа болно. Мөн “МИАТ” ТӨХК болон агаарын тээвэрлэгчдийн хувьд агаарын хөлгийн шатахууныг үйлдвэрлэгчээс худалдан авахын тулд газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх тусгай зөвшөөрөл авах шаардлагатай, мөн их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах, агаарын тээврийн бус бизнесийн үйл ажиллагаа тул хэрэгжүүлэх боломжгүй болсон. Шатахуун хангамжийн үйлчилгээнд өрсөлдөөн бий болгох, агаарын</p>	<p>Баруун, зүүн бүсийн хилийн боомтоор агаарын хөлгийн шатахуун оруулж ирэх боломжийг бүрдүүлж, гаалийн татварыг "0" (тэг) хувиар тогтоолгох, Улаанбаатар хотоос орон нутагт шатахуун тээвэрлэх зардлыг бууруулах, шатахууныг олон эх үүсвэрээс авах, үнийг бууруулах талаар судалгаа хийж, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Зам, тээврийн яаманд 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/2094 тоот албан бичгээр хүргүүлсэн</p>	<p>Эрх зүйн зохицуулалтын хувьд шууд худалдан авах эрх нь газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд нээлттэй байна. Судалгаагаар агаарын тээврийн компанид тусгай зөвшөөрөл авч бизнесийн өөр төрөлд хөрөнгө оруулалт хийх их хэмжээний эргэлтийн хөрөнгө</p>	<p>Эрх зүйн хувьд газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд нээлттэй байгаа тул энэ зохицуулалтыг бүрдүүлэх боломжгүй байгааг харгалзан хяналтаас хасуулах саналтай байна.</p>

		<p>тээвэрлэгчдэд ижил үнээр нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Зам, тээврийн яам, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт холбогдох тооцоо судалгаа, мэдээллийг хүргүүлсэн. /2015.01.23-ны 01/160 тоот болон ЗТЯ-д 2015.10.30-ны өдрийн 02/2645 тоотой, ШӨХТГ-т 2015.03.30-ны 07/557 тоотой/ “МИАТ” ТӨХК-нь нислэг гүйцэтгэж буй нисэх нисэх буудлаас агаарын хөлгийн шатахууныг биржийн үнээр худалдан авах зохицуулалтыг хийсэн. 2015 онд шатахууны үнэ буурч, тогтвортой байгаа бөгөөд 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар /722 ам доллар/ болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>	шаардагдах тул эдийн засгийн чадамжийн хувьд хэрэгжүүлэх боломжгүй байгаа болно.	
4.	<p>“Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн баталгаат эрхийн тухай конвенци”, түүний “Агаарын хөлөгт тусгайлан хамаарах протокол”-ыг хэрэгжүүлэх, худалдан авах агаарын хөлгөөр барьцаалан зээл авах ажиллагааг зохицуулах дотоодын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Эрх зүйн зохицуулалт бүрдүүлсэн байна. Санхүүгийн баталгааг олон улсын конвенцийн дагуу хэрэгжүүлэх тогтолцоо бүрдэнэ.</i> Хугацаа: 2014-2015 он АТЭЗЗГХАГ</p>	<p>“Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн баталгаат эрхийн тухай конвенци”, түүний “Агаарын хөлөгт тусгайлан хамаарах протокол”-ыг хэрэгжүүлж байгаагийн илрэл нь МИАТ ХК-ийн шинээр худалдан авсан Б767-300ER агаарын хөлгийн зээл, санхүүжилт хийгдэж байгаа байдал, дотоодын эрх зүйн орчин бүрдсэнийг харуулж байна Санхүүгийн баталгааг олон улсын конвенцийн дагуу хэрэгжүүлэхэд төрийн зүгээс хувийн хэвшлийн агаарын тээвэрлэгч хэрхэн дэмжих талаарх дотоодын эрх зүйн орчны судалгааг хийж, 2015.10.23-ны өдрийн 01/2562 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. “Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн баталгаат эрхийн тухай конвенци”, түүний “Агаарын хөлөгт тусгайлан хамаарах протокол”-ын дагуу “МИАТ” ХК-ийн шинээр худалдан авсан Б767-300ER агаарын хөлгийн санхүүжилтийг агаарын хөлгөө баталгаа болгон АНУ-ын Эксим банкнаас авч санхүүжүүлсэн. Дотоодын эрх зүйн орчныг бүрдсэнийг харуулж байна.</p>	/Хэрэгжилт 30%/	Одоогоор энэ зохицуулалтыг бүрдүүлэх эрх Монгол Улсын хууль тогтоомжоор ЗТЯ, ИНЕГ-т олгогдоогүй тул олон улсын гэрээний зохицуулалтыг баримтлан хэрэгжүүлж байгаа болно.

		/Хэрэгжилт 100%/			
5.	<p>Олон улсын нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний зориулалттай техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжсэн байна. Иргэний нисэхийн үйлчилгээний чанар, үр ашиг дээшилж, үйлчилгээний үнэ өртөг буурна.</i></p> <p>Хугацаа: 2014-2015 он АТЭЗЗГХАГ</p>	<p>Олон улсын нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний зориулалттай техник, тоног төхөөрөмжийг Нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас чөлөөлүүлэх тооцоо судалгаа хийж, 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 02/555 албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхтэй холбогдуулан судалгаа хийсэн. Татварын хөнгөлөлт үзүүлэхэд иргэний нисэхийн салбарт үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон. ИНЕГ-аас хамаарах судалгааны ажлууд хийгдсэн.</p> <p style="text-align: center;">/Хэрэгжилт 70%/</p>	<p>Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ"-г нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан 2016 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 01/625 тоот, 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1765 тоот албан бичгүүдээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Яамдаас санал авсан бөгөөд Сангийн яамнаас уг хуулийн төслийг дэмжихгүй байна.</p> <p style="text-align: center;">/Хэрэгжилт 70%/</p>		
6.	<p>Иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлөг, түүний сэлбэг, тоног төхөөрөмжүүд, агаарын хөлгийн шатахууныг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг бүрдүүлнэ.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна. Иргэний нисэхийн үйлчилгээний чанар, үр ашиг дээшилж, үйлчилгээний үнэ өртөг буурна.</i></p> <p>Хугацаа: 2014-2015 он АТЭЗЗГХАГ</p>	<p>Иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлөг, түүний сэлбэг, тоног төхөөрөмжүүдийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар Гаалийн болон НӨАТатварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Засгийн газрын 2014 оны 33 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. УИХ-ын 2014 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэн, хуулийн төслүүдийг хэлэлцэхээр тогтоод байна. Засгийн газрын 2014 оны 22 болон 140 дүгээр тогтоолоор Сүхбаатар, Замын-Үүд боомтоор импортолсон агаарын хөлгийн шатахууны гаалийн албан татварыг "0" (тэг) хувиар тогтоосон. Иргэний агаарын хөлөг, түүний сэлбэгийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэхээр холбогдох хуулийн төслийг 2014 оны 10 дугаар сард УИХ-д</p>	<p>Дэлхийн худалдааны байгууллагын олон талт хэлэлцээрийн "Иргэний агаарын хөлөг худалдах хэлэлцээр"-т нэгдэн орох тухай шийдвэрийн төсөл, танилцуулга болон Монгол хэл дээрх орчуулгыг 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/549 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Тус хэлэлцээрт нэгдсэн орсноор Иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын хөлөг, түүний сэлбэг, тоног төхөөрөмжүүдийг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ. Зам, тээврийн яамнаас УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг</p>		<p>"Иргэний агаарын хөлөг худалдах хэлэлцээр"-т нэгдэн орох</p>

		<p>өргөн мэдүүлсэн. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал дэмжигдэхгүй хүлээгдэж байгаа болно. Шинэ нисэх буудалд суурилуулах тоног төхөөрөмжийг зээлийн гэрээний дагуу татвараас чөлөөлүүлэхээр тусгагдсан. Агаарын тээврийн салбарт ашиглах импортоор оруулж байгаа/ зүүн, баруун бүс/ агаарын хөлгийн шатахууны гаалийн албан татварыг “0” хувиар тогтоох тогтоолын төсөлд яамдаас санал авсан бөгөөд Сангийн яам урд, хойд бүсээр импортлосон агаарын хөлгийн шатахууны гаалийн албан татварыг “0” (тэг) хувиар тогтоосон нь хир зэрэг үр өгөөжөө өгсөн талаар судалгаа хийж, танилцуулсны дараа асуудлыг шийдвэрлүүлэх санал өгсөн.</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>	<p>батлан, Хууль зүйн яамтай хамтран батлуулахаар ажиллаж байна.</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>			
7.	<p>Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээрийн “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т нэгдэх асуудлыг шийдвэрлүүлнэ.</p> <p>Хүрэх үр дүн: Эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна. Хугацаа: 2014-2015 он АТЭЗЗГХАГ</p>	<p>“Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-ийг орчуулж, танилцуулга бэлтгэж АТБХЗХ-д цахим шуудангаар илгээсэн ба ОУ-ын конвенцид нэгдэх арга хэмжээ 2016 он хүртэл хойшилсон тул ажил удааширч байна. Зам, тээврийн яамнаас УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг батлан Хууль зүйн яамтай хамтран батлуулахаар ажиллаж байна.</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>	<p>“Дэлхийн худалдааны байгууллагын олон талт хэлэлцээрийн “Иргэний агаарын хөлөг худалдах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох тухай шийдвэрийн төсөл, танилцуулга болон Монгол хэл дээрх орчуулгыг 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/549 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн.</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>		<p>“Иргэний агаарын хөлөг худалдах хэлэлцээр”-т нэгдэн орох</p>	
8.	<p>Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” болон уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хэлэлцээрийг байгуулна.</p> <p>Хүрэх үр дүн: Хэлэлцээр, ажлын хэлэлцээрийг байгуулсан байна. Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа сайжирна. Хугацаа: 2013-2014 он</p>	<p>Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” нь 2014 оны 12 дугаар сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” –ийг хэрэгжүүлэх ажлын хэлэлцээрийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталгаажуулсан.</p>				

	НХУГ	/Хэрэгжилт 100%/			
9.	<p>Монгол Улсын Засгийн газар, БНКАЗУ-ын Засгийн газар хоорондын “Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” болон уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хэлэлцээрийг байгуулна.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Хэлэлцээр, ажлын хэлэлцээрийг байгуулсан байна. Иргэний нисэхийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа сайжирна.</i></p> <p>Хугацаа: 2014-2020 он НХУГ</p>	<p>Монгол Улсын Засгийн газар, БНКАЗУ-ын Засгийн газар хоорондын “Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан, 2015 оны 01 дүгээр сарын 20-ны 01/124 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Энэ оны 06 дугаар сард хуралдсан Монгол Улс, БНКАЗ Улс хоорондын Засгийн газрын хуралдааны үеэр хэлэлцээрийн төслийг Казакстаны талд хүргүүлсэн бөгөөд одоогоор хариу ирүүлээгүй байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>		<p>Казакстаны талд хүргүүлсэн бөгөөд одоогоор хариу ирүүлээгүй байна.</p>	<p>Дипломат харилцааны шугамаар хөөцөлдөх</p>
10.	<p>Шинээр барих олон улсын нисэх буудлыг зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа болгох төлөвлөлтийг батална.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Шинээр баригдаж буй олон улсын нисэх буудлыг зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа болгох арга хэмжээний төлөвлөлттэй болно.</i></p> <p>Хугацаа: 2014-2015 он НБУГ</p>	<p>Улаанбаатар холимог тээврийн нэгдсэн терминалыг Хөшигийн хөндий дэх шинэ нисэх онгоцны буудлын дэргэд байгуулахаар тохиролцон, Улаанбаатар хотын 2020 он хүртэл ерөнхий төлөвлөгөөнд байршлыг тусгуулсан. 400 га газрын зөвшөөрлийг авсан. “Богдхан” төмөр зам төсөл болон шинэ нисэх буудлыг түшиглэн барих “Улаанбаатар хотын логистик төвийн” ТЭЗҮ боловсруулах төслийг АХБ-нд танилцуулж, 2014-2016 онд АХБ-ны санхүүжүүлэлтээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад “Богдхан” төмөр зам төсөлтэй Улаанбаатар хотын логистик төвийн төслийг уялдуулж оруулсан. Агаарын ачаа тээвэр, логистикийн судалгаа хийж, бодлогын санал, боловсруулан 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/2973 албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Богдхан төмөр зам төслийн хүрээнд баригдах УБ холимог тээврийн нэгдсэн терминалын ажлын даалгавартай холбогдуулан агаарын ачаа тээвэр, логистикийн судалгаа хийж, бодлогын санал, боловсруулан 2014.12.12-ны 01/2973 албан бичгээр ЗТЯ-д</p>		<p>Хөрөнгө оруулалтаас шалтгаалж хугацаа хоцорч байгаа.</p>	

		хүргүүлсэн.Цаашид шаардлагатай үед холбогдох мэдээлэл, судалгааг тухай бүр гаргаж өгнө. /Хэрэгжилт 30%/			
11.	“Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”-ийг батална. Хүрэх үр дүн: Хөтөлбөр батлагдсан байна. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа сайжирна. Хугацаа: 2013-2014 он НААХЗГ	Иргэний нисэхийн Аюулгүй ажиллагааны хөтөлбөр /“State Safety Programme”/ –ийг Зам, тээврийн сайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар батлууллаа. /Хэрэгжилт 100%/	Иргэний нисэхийн Аюулгүй ажиллагааны хөтөлбөр /“State Safety Programme”/ –ийг Зам, тээврийн сайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар батлууллаа. /Хэрэгжилт 100%/		
12.	Ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, агаарын зай, аэродром, буух талбай, нисдэг тэрэгний тавцан, агаарын хөлөг, бүртгэл, техник үйлчилгээ, нисгэгч бэлтгэх зэрэг үйл ажиллагааны зохицуулалтыг хамарсан “Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлнэ. Хүрэх үр дүн: Хөтөлбөр батлагдсан байна. Ерөнхий зориулалтын агаарын тээвэр хөгжинө. Хугацаа: 2013-2020 он НААХЗГ, НХУГ	Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг эцсийн байдлаар хянаж, саналыг нэгтгэн, уг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. /Хэрэгжилт 30%/	“Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг эцсийн байдлаар хянаж, саналыг нэгтгэн, уг хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. /Хэрэгжилт 70%/	“Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг дахин боловсруулах, эдийн засгийн тооцоо судалгааг хийх	
13.	Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн аэродром, нисдэг тэрэгний хөөрч буух тавцан барьж байгуулах ажиллагааг дэмжиж, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхийн тулд “Хот байгуулалтын тухай” болон “Барилгын тухай” хуулиудад нэмэлт оруулан, холбогдох дүрэм, стандартыг батлуулан мөрдүүлнэ. Хүрэх үр дүн: Эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн аэродром, нисдэг тэрэгний хөөрч буух тавцан байгуулах стандарт бий болно. Хугацаа: 2014-2015 он НААХЗГ, НБУГ	Хэлипорттой холбоотой зохицуулалтыг ИНД139 “Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт” дүрэмд оруулж, Зам, тээврийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлэхээр ХЗЯ-нд хүргүүлсэн. Хэлипортын стандартыг боловсруулсан. /Хэрэгжилт 50%/			Хотын дүрэм төслийн хүрээнд боловсруулж байгаа барилга байгууламж дээр хелипорт барих стандарттай уялдуулан боловсруулсан Хэлипортын стандартыг дахин нягтлах, батлуулах

14.	<p>АНУ-тай “Нээлттэй агаарын зайн хэлэлцээр” байгуулах хэлцлийг эхлүүлнэ. Хүрэх үр дүн: Хэлэлцээр байгуулсан байна. Монгол Улсыг чиглэсэн нислэгийн давтамж нэмэгдэнэ. Хугацаа: 2016 оноос</p>				
15.	<p>Алслагдсан бүс нутагт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг баталж, тухай бүр шинэчилж байна. Хүрэх үр дүн: Хөтөлбөр батлагдсан байна. Агаарын тээврийн үйлчилгээ алсагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүрнэ. Хугацаа: 2014-2020 он АТЭЗЗГХАГ</p>	<p>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн төслийг энэ оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/1301, 09 дүгээр сарын 07-ны өдрийн 01/2112 тоот албан бичгүүдээр Зам, тээврийн яаманд батлуулахаар хүргүүлсэн. Алслагдсан бүс нутгийн ард иргэдэд агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Сумдын нислэгийг сэргээх талаарх танилцуулга, уулзалт”-ыг Ховд, Увс, Завхан, Говь-алтай аймагт 2015 оны 06 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд, Зүүн бүсийн Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудад энэ оны 08 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд Хэнтий аймагт, Төвийн бүсийн Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Орхон аймгуудад энэ оны 09 дүгээр сарын 03-08-ны өдрүүдэд, Булган аймагт зохион байгуулсан. IXэрэгжилт 70%I</p>		<p>Улс орны нийгэм эдийн засгийн хямралаас шалтгаалан тус хөтөлбөрийг батлах хэрэгжүүлэх үйл ажиллагаа хойшлогдоод байна. Орон нутагт хатуу хучилттай авто зам ашиглалтад орсонтой холбогдон Улаанбаатар хот аймгийн төв хоорондох орон нутгийн хуваарьт нислэгүүд зогсох, хумигдах байдалтай болоод байгаа одоогийн нөхцөлд алслагдсан бүс нутагт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг нэвтрүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдалтай байна.</p>	
16.	<p>“Иргэний нисэхийн салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг батлан, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хүрэх үр дүн: Хөтөлбөр батлагдсан байна. Олон улсад</p>	<p>ИНЕГ-аас боловсруулж ирүүлсэн “Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хянасан. Иргэний</p>		<p>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг</p>	

	<p>хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг хангасан бүтцийн шинэчлэлийг хийнэ. Хугацаа: 2014-2016 он ХЭЗГ</p>	<p>нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа тус газрын бүтэц, зохион байгуулалтын асуудлыг авч үзэх чиглэлийг Зам, тээврийн сайдаас өгсөн тул хөтөлбөрийн баталгаажуулалт хойшлогдоод байна.</p> <p>"Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтцийг боловсронгуй болгох" танилцуулга, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Зам, тээврийн яамны СТБГ-т хүргүүлсэн. Улмаар уг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэгжүүлж байсан агаарын навигаци, агаарын хөлгийн газрын болон нисэх буудлын үйлчилгээ, бусад аж ахуйн үйл ажиллагаатай холбогдох чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх "Иргэний нисэхийн үндэсний корпораци" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсан. Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрмийг шинэчлэн боловсруулж, Засгийн газраар батлуулсан. Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэгжүүлж байсан зарим чиг үүргийг "Иргэний нисэхийн үндэсний корпораци"-д шилжүүлсэнтэй холбогдуулж Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг дахин боловсруулан энэ оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 01/1220 албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. /Хэрэгжилт 50%/</p>		<p>батлуулсны дараа хэрэгжих тул хугацаа хоцорч байгаа.</p>	
17.	<p>Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын зарим төрлийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагад концессын гэрээний үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлнэ. Хүрэх үр дүн:</p>	<p>Нисэх онгоцны шинэ буудлын менежментийн бүтцийн санал боловсруулах Зөвлөх багаар Япон Улсын "Номура" Судалгааны Хүрээлэн болон "Стратежик Партнерс" компанийн түншлэл шалгарч, 2014 оны 09 дүгээр</p>	<p>Төслийн барилгын ажилтай зэрэгцэн шинэ нисэх буудлын менежментийг концессийн гэрээгээр гүйцэтгүүлэх шийдвэрийн дагуу Ерөнхий сайдын 2015</p>		

	<p>Концессийн гэрээ байгуулагдсан байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл бий болно. Хугацаа: 2016 оноос НБУГ</p>	<p>сараас судалгааны ажлаа эхлүүлж, судалгааны санал дүгнэлтийг Ашиглалтын өмнөх удирдах хорооны 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр хуралдаанд танилцуулсан. Зөвлөх баг нисэх онгоцны шинэ буудлын менежментийг хэрэгжүүлэгч байгууллага нь аэродромын хэсгийн байгууламж (airside) болон аэродромын гаднах хэсгийн байгууламжийн (landside) бүх үйл ажиллагааг хамтад нь эрхлэн явуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан. Улмаар нисэх онгоцны шинэ буудлын удирдлагыг хэрэгжүүлэгч байгууллага нь доорх 4 төрлийн менежменттэй байх боломжтой талаар танилцууллаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн шууд удирдлагаар хэрэгжүүлэх; 2. Менежментийн гэрээгээр удирдуулах; 3. Төр, хувийн хэвшлийн түншлэл буюу концессын гэрээгээр удирдуулах; 4. Урт хугацааны түрээсийн гэрээгээр хувийн хэвшлээр удирдуулах. <p>Дээр дурдсан 4 хувилбар тус бүрийг 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Зам, тээврийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулж, Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэл буюу концессын гэрээгээр гүйцэтгүүлэх шийдлийг оновчтой хэмээн сонгож, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ажлыг ЗТЯ-ны Төрийн нарийн нарийн бичгийн дарга, Стратеги, бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газарт тус тус даалгасан. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын хавсралтад "Улаанбаатар хотын Олон улсын нисэх</p>	<p>оны 209 дүгээр захирамж төсөл хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг томилогдон ажиллаж байна. Тус менежментийн төсөлд оролцохоор Япон Улсын Мицубиши корпораци тэргүүтэй дөрвөн компанийн хамтарсан консорциум саналаа ирүүлсэн бөгөөд одоогоор Оролцогч талаас ирүүлсэн саналыг үнэлэх шатанд байгаа болно.</p>		
--	---	---	---	--	--

		<p>онгоцны шинэ буудлын менежментийг гүйцэтгүүлэх” ажлыг тусгуулахаар 2015 оны 01/3393 дугаар албан бичгээр санал авсан. 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр ЗТЯ-ны ТНБД Ж.Бат-Эрдэнэ, Аж, үйлдвэрийн яамны ТНБД Д.Нямхүү, Хөрөнгө оруулалтын газрын дарга Батбаяр болон ЗТЯ-ны төлөөлөл хуралдаж, шинэ нисэх буудлыг концессоор гүйцэтгүүлэх шалгуур үзүүлэлт, боломжит хувилбаруудын талаар судалж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Зам, тээврийн сайд болон Аж, үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалаар томилохоор тогтоод байгаа. Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 54 дүгээр хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, нисэх онгоцны шинэ буудлын менежментийг гүйцэтгүүлэх ажлыг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулахаар болсон. Мөн хуралдаанаар Японы талтай хэлэлцээ хийхийг зөвшөөрсөн шийдвэр гаргасан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 70%/</p>			
18.	<p>Бүс нутагтаа тэргүүлэх хэмжээний агаарын навигацийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор техник технологийн шинэчлэлийг хийнэ.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Техник технологийн шинэчлэл хийгдсэн байна. Аюулгүй ажиллагаа сайжирна.</i></p> <p>Хугацаа: 2014-2020 он НХУГ</p>	<p>Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас стратегийн зорилт болгон дэвшүүлсэн "Global Air Navigation Plan", "Aviation System Block Upgrade" зэрэг төсөл хөтөлбөрүүдэд судалгаа хийж , 2017-2023 оны төлөвлөгөөг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2015 оны А/836 дугаар тушаалаар батлуулсан. 2014 онд 5 иж бүрдэл ADS-B төхөөрөмжийг худалдан авч суурилуулалтын ажлыг төв төхөөрөмжийн хамт суурилуулж бүрэн дууссан. Өнөөгийн байдлаар гэрчилгээжүүлэх ажил хийгдэж байна. Тус төхөөрөмжийг 2015 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс туршилтаар ашиглаж эхэлсэн. 2015 оны 4 сард үзүүлэлтэд тулгуурласан навигацийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн дагуу</p>			

		<p>Улаанбаатар, Мөрөн нисэх буудлуудад RNP нислэгийн журмыг зохион, шалгалтын нислэгийн ажлыг БНХАУ-ын шалгалтын нислэгийн багтай хамтран гүйцэтгэсэн. Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Дорноговь аймгийн Сайхандулаанд шинээр хоёр ажиглалтын станц суурилуулан, энэ оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. Ингэснээр дээд агаарын зайн радарын бүрхэлт сайжирч, өгөгдлийг илүү нарийвчлалттай хянах чадамжтай болж байгаа бөгөөд нийт агаарын зайн ажиглалтын бүрхэлт 80%-д хүрч, өнгөрөлтийн нислэгийн 90%-ийг ажиглалтын удирдлагаар хангах боломжтой болж байна.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд Зай хэмжих /DME/ 10 тоног төхөөрөмж, MASCOM-VSAT сансрын холбооны төв станц болон 11 алсын станцын хамт IDU төхөөрөмжүүдийг тус тус суурилуулсан.</p> <p style="text-align: center;">/Хэрэгжилт 70%/</p>			
19.	<p>Орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-тай уялдуулан бүсийн зангилаа (Hub) буудлуудыг байгуулна.</p> <p>Хүрэх үр дүн: Зорчигч, ачаа тээврийн урсгал нэмэгдсэн байна.</p> <p>Орон нутгийн нисэх буудлуудыг хөгжүүлнэ.</p> <p>Хугацаа: 2014-2020 он НБУГ</p>	<p>Ховд аймаг дахь нисэх буудлыг олон улсын 4С ангиллын нисэх буудал болгох ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжуудыг шинээр төлөвлөх ажлын ТЭЗҮ, ажлын зургийн даалгаврыг шинэчлэн ИНЕГ-ын даргаар батлуулсан. Ховд аймаг дахь нисэх буудлын аэродромыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах зураг төслийг “ЭЗТ” ХХК боловсруулан, Улсын хяналтын төсвийн 23,296,360,731 төгрөгөөр хянаж баталгаажуулсан. Одоо 23,3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж аэродромын барилга угсралтын ажлыг эхлүүлэх шаардлагатай. Мөн Ховд нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын зураг төслийг боловсруулах даалгаврыг боловсруулан ИНЕГ-ын даргаар батлуулан, зөвлөхийг сонгон</p>	<p>Ховд нисэх буудлын аэродромын зураг төсвийг “ЭЗТ” ХХК боловсруулж, улсын экспертизээр хянан баталгаажуулсан. Барилга байгууламжийг 4С болгох зураг төсөл боловсруулах даалгавар батлагдсан. Польш улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлд хамруулахаар Ховд аймгийн “Ховд” нисэх буудлын аэродромыг 4С зэрэглэлд нийцүүлэн байгуулах ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг англи хэлээр хөрвүүлэн, ЗТЯ-нд хүргүүлсэн.</p> <p style="text-align: center;">/Хэрэгжилт 30%/</p>		

		<p>шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зохион байгуулсан боловч төсөвт өртөг бага гэдэг шалтгаанаар компаниуд материал ирүүлээгүй болно.</p> <p>Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг Засгийн газрын 2013 оны 428-р тогтоолоор олон улсын нөөц нисэх буудал болгохоор шийдвэрлэсэн ба олон улсын 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах нисэх буудал болгох зургийн даалгаврыг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.</p> <p>Хөвсгөл аймаг дахь нисэх буудлыг 4С болгох ажлын хүрээнд нисэх буудлыг зорчигч үйлчилгээний барилгыг цагт 150 зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай болгосон ба аэродромыг 4С болгох ажлын хүрээнд эхний ээлжийн 648 метр урт зурвасыг өргөтгөж хүчитгэсэн. Гэвч 2-дугаар ээлжийн ажлын төсөвт өртгийг 2013, 2014 оны Улсын төсөвт суулгасан боловч гэрээ байгуулагдаагүй тул эх үүсвэрийг хураалгасан.</p> <p>Дорнод аймаг дахь нисэх буудлыг 4С болгох ажлын зураг төслийг боловсруулж байна.</p> <p>/Хэрэгжилт 30%/</p>			
20.	<p>Даланзадгадын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон бүрэн ашиглалтад оруулна.</p> <p>Хүрэх үр дүн: <i>Нөөц нисэх буудалтай болсон байна.</i> Хугацаа: 2014-2018 он НБУГ</p>	<p>Даланзадгадын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох ажил Концессийн тухай хуулиар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад орсон. ЭЗХЯ зохион байгуулсан ЭЗХЯ, Сингапурын хөгжлийн агентлаг, Зам, тээврийн яам, Төрийн банк, ИНЕГ-ын болон бусад байгууллагуудын төлөөллүүд оролцсон 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлаас Өмнөговь аймгийн “Гурван сайхан” нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох төслийг хэрэгжүүлэх хамтарсан ажлын хэсэг томилон ажиллуулахаар шийдвэрлээд байна. Тус нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий</p>		Санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлээгүй байгаа.	Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг олон улсын 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах нисэх буудал болгох ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг таслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний болон эсвэл бүхэлд нь гүйцэтгэх ажлын санхүүжилтыг шийдвэрлүүлж, хэрэгжүүлэх

		<p>төлөвлөгөө, зураг төслийн ажлын даалгаврыг 2015 оны 09 дүгээр сард Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.</p> <p>/Хэрэгжилт 30%/.</p>			
21.	<p>Олон улсын Иргэний нисэхийн тухай конвенцийн дагуу агаарын навигацийн үйлчилгээний хураамжийг иргэний нисэхийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалтад зарцуулах тогтолцоог бүрдүүлэх.</p> <p>Хүрэх үр дүн: Санхүүжилтын тогтолцоог бүрдүүлсэн байна. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хангалт сайжирна.</p> <p>Хугацаа: 2014-2015 он ХЭЗГ, НХУГ</p>	<p>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 47 дугаар зүйлийн 47.2-д АНУ-ний байгууллага нь агаарын навигацийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулна. гэж хуульчилж оруулсан.</p> <p>/Хэрэгжилт 70%/.</p>	<p>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 47 дугаар зүйлийн 47.2-д АНУ-ний байгууллага нь агаарын навигацийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулна. гэж оруулсан.</p> <p>/Хэрэгжилт 70%/.</p>	<p>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажил удааширч байгаа тул энэ арга хэмжээ мөн хангалтгүй хэрэгжиж байна.</p>	
22.	<p>Агаарын хөлгийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг олон улсын холбогдох зөвлөмжийн дагуу тогтоон, хураамж авах тогтолцоог бүрдүүлнэ.</p> <p>Хүрэх үр дүн: Хураамж авах хэмжээ, тогтолцоо бүрдсэн байна.</p> <p>Хугацаа: 2018 оноос</p>	<p>/ Хугацаа болоогүй./</p>	<p>/ Хугацаа болоогүй./</p>		
23.	<p>Олон улсын нисэх буудал, аэродромын дэд бүтэц, агаарын навигацийн тоног төхөөрөмжийг хувьчилж үл болох салбарын жагсаалтад оруулж, холбогдох шийдвэрийг гаргана.</p> <p>Хүрэх үр дүн: Холбогдох шийдвэр гарсан байна.</p> <p>Хугацаа: 2014-2020 он ХЭЗГ</p>	<p>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 46 дугаар зүйлийн 46.2-д “Агаарын навигацид хэрэглэгдэх холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжийн нэгдмэл сүлжээ нь төрийн өмч байна.”, 52 дугаар зүйлийн 52.4-д Олон улсын нисэх буудал нь олон улсын стандартыг хангасан байх ба эзэмшил газар нь төрийн тусгай хамгаалалтад, барилга байгууламж, тоног төхөөрөмж нь төрийн өмчлөлд байна. гэж хуульчилж оруулсан. “Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай ” Улсын Их</p>	<p>Улсын Их Хурлын “Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай” 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралтад агаарын навигацийн үйлчилгээний холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн нэгдсэн сүлжлийг нэмж оруулахтай холбогдуулан тус тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төсөл,</p>		

		<p>Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралтад агаарын навигацийн үйлчилгээний холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжүүдийн нэгдсэн сүлжлийг нэмж оруулахаар Улсын Их хурлын тогтоолын төсөл, танилцуулга, тоног төхөөрмжийн жагсаалтын хамт 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/2931 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд албан бичгээр хүргүүлэв</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>	<p>тогтоолын төсөл, танилцуулгыг тус тус боловсруулж, 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/551 тоот албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Яамдаас санал авч байна.</p> <p>/Хэрэгжилт 70%/</p>		
24.	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан олон улсын нисэх буудал, аэродром, холбоо, навигаци, бодит ажиглалтын тоног төхөөрөмж болон томоохон нисэх буудлын дэд бүтэц, барилга байгууламжийг төрийн өмчийн бүртгэл, хяналтад оруулна.</p> <p>Хүрэх үр дүн: Хугацаа: 2014-2020 он СЭЗГ</p>	<p>2013 онд Өмнөговь, Сүхбаатар аймагт суурилуулсан бодит ажиглалтын систем, 2015 онд Сайхандулаан, Бөмбөгөрт суурилуулсан радиолокатор, 2013-2014 онд суурилуулсан 10 иж бүрдэл ADS-B станц, 2014 онд суурилуулсан 10 иж бүрдэл DME435 болон Увс аймаг дахь Нисэх буудалд суурилуулсан гэрэл суурилалтын системийг үндсэн хөрөнгөд тус тус бүртгэсэн. 2015 онд Сайхандулаан, Бөмбөгөрт суурилуулсан радиолокаторыг үндсэн хөрөнгөд тус тус бүртгэсэн.</p> <p>/Хэрэгжилт 90%/</p>			